


МОНГОЛТРАНС ХХК



САЙХАН ИРЭЭДҮЙ РҮҮ ХАМТДАА | MTC@MONGOLTRANS.MN

Ү



КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Олон улсын тээвэр үйлчилгээний “Монголтранс” ХХК 1991 онд байгуулагдсан цагаас хойш өнөөдрийг хүртэл 31 жилийн турш тээврийн салбарт үйл ажиллагааг жигд тогтвортой явуулж байгаа хамт олон.

Манай компани нь үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг олсон, тээврийн салбартаа мэргэшсэн, мэргэжлийн өндөр түвшний баг хамт олон юм.



Бидний 31 жилийн хугацааны үйл ажиллагааг өндрөөр үнэлж Дэлхийн чанарын байгууллагаас 3 удаа алтан цомоор шагнасан нь манай амжилтын томоохон үзүүлэлт бахархал мөн юм.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ



ЭРХЭМ ЗОРИЛГО

- Ачаа тээвэр, ложистикийн чанартай, аюулгүй, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх нь бидний эрхэм зорилго билээ.

АЛСЫН ХАРАА

- Тээвэр ложистикийн шилдэг байгууллага болох.

ҮНЭТ ЗҮЙЛ

- Үйлчлүүлэгч
- Мэргэшсэн хамт олон
- Аюулгүй ажиллагаа



ДАВУУ ТАЛ

- Бид 31 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулсны эцэст үйлчлүүлэгчдэдээ дараах давуу талуудыг ашиглах боломжийг нээж өгсөн юм.
- Мэргэшсэн баг хамт олон
- Бүх төрлийн тээврийн үйлчилгээ
- Боломжит үнэ, төлбөрийн уян хатан нөхцөл
- Тээврийн хамгийн өргөн сүлжээ
- Даатгал, хамгаалалт, хүргэлт
- Механикжсан талбай, өөрийн эзэмшлийн салбар зам
- Улсдаа хамгийн том талбайтай гаалийн хяналтын бүс, гаалийн нэг цэгийн үйлчилгээ

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС

Улаанбаатар хот дахь хамгийн том талбайтай гаалийн хяналтын бүс, нэг жилд 500,0 мянган тонноос дээш ачааг боловсруулах талбай, өөрийн эзэмшлийн салбар төмөр зам, автозамын салаа орц гарцтай дотоод үйлчилгээний зам талбай, гаалийн нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан ачаа барааг хүлээн авах, хадгалах, ачиж буулгах, түгээх, гаалийн бүрдүүлэлт хийх зэрэг ажил үйлчилгээг нэг цэгт гүйцэтгэх иж бүрэн үйлчилгээг боломжит үнэ, төлбөрийн уян хатан нөхцөлтэйгөөр та бүхэнд үзүүлэхэд бид бэлэн байна.

ТЕРМИНАЛ-ЛОГИСТИК ТАЛБАЙ

Монголтранс терминал-логистикийн төв нь задгай болон битүү вагоны ялган боловсруулах хүчин чадал бүхий 2 салбар төмөр замаар өдөртөө 80 вагон (боловсруулах боломжтой) ба гаалийн хяналтын бүсийн 7000м² талбайд 500-800ш контейнерийн боловсруулалт хийгдэнэ. Талбайд задран ачаа бараа олгох 100-150 чингэлэгний хүчин чадалтай талбай, бусад 43000м² талбайд хоосон чингэлэг 1000ш байрлуулах боломжтой, ХАА-н машин механизм, техникийг өөрийн хөлөөр нь буулгах зориулалттай өндөрлөсөн 1173м² бетон тавцан, гаалийн авто рентген байгууламж, задгай болон битүү вагоны буулгалт, автомашин, уул уурхайн техник хэрэгсэл, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжүүд, зам тээврийн төслийн тоног төхөөрөмж зэрэг овор ихтэй ачаа барааг задгай талбайд буулгаж хадгалах гэх мэт олон зүйл зориулалтаар ашиглаж байгаа билээ.

ОЙРЫН ЗОРИЛГО

Бид цаашид үйл ажиллагаагаа өргөтгөх үүднээс гаалийн баталгаат агуулах, гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч, агуулах зэргийг барьж байгуулахаар ойрын хугацааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх шатандаа явж байна.

Үйл ажиллагааны түүхийн товчлол

- [1991 он](#): Гадаад орны 20-иод пүүс компанитай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулж хамтран ажиллаж эхлэв.
- [1992 он](#): Япон улсын компаниудтай ажил төрлийн холбоо тогтоож Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн төсөлд оролцож барилгын материал, тоног төхөөрөмжийг суурилуулах тээвэрлэлтийг зуучлан зохион байгуулсан.
- [1993-1998 он](#): Буюнт-Ухаагийн нисэх буудлын өргөтлөг, Улаанбаатар-Эрдэнэ сумын авто замын байгууламжийн төсөл, II, III, IV, цахилгаан станцын өргөтгөлийн төслийн ачааны тээвэрлэлтийг гүйцэтгэв.
- [1996-1998 он](#): Хотын нийтийн тээврийн 120 автобус, нийгмийн халамжийн бага оврын машиныг оруулж хэрэглэгчдэд хүлээлгэн өгсөн.
- [1999-2001 он](#): Англи болон Финланд улсаас комбайн, тоног төхөөрөмжийн тээвэр.
- [2000 он](#): Багануур дахь нүүрсний уурхайн тээвэрлэлтийг хийж гүйцэтгэж байсан.
- [2001 он](#): Казахстан улсаас 8000 тонн улаан буудайн тээврийг хийж гүйцэтгэж байсан.
- [2000-2003 он](#): Японы засгийн газрын буцалтгүй тусламжаар төслийн хүрээнд 7 аймгийн 51 сумын төвд суурилуулах 120 дизель станцын тээвэрлэлтийг зуучлан зохион байгуулж хэрэглэгчдэд нь хүргэж өгсөн. Газар тариаланг дэмжих KR-2 төслийн тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгэх тендерт шалгарч Финлянд улсаас 40 орчим тракторыг Монголд тээвэрлэн оруулж ирсэн. НҮБ-аас буцалтгүй тусламж болгосон 30 мянган тонн тэжээлийг хөдөөгийн сумдад хүргэх ажлыг гүйцэтгэв.
- [2002 он](#): Шивээ овоо дахь нүүрсний уурхайн тоног төхөөрөмжийн тээврийг хийж гүйцэтгэв.
- [2002 он](#): Амьд тахь тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэв.
- [2003 он](#): 25000 тонн улаан буудайн тээврийг хийж гүйцэтгэв.
- [2003-2004 он](#): Тайваниас 7000 тонн цагаан будааны тээврийг хийж гүйцэтгэв.
- [2003-2005 он](#): Австралийн Рок ойл компанийн нефтийн хайгуул олборлолтын иж бүрэн тоног төхөөрөмж, овор хэтэрсэн 35 вагон ачааг Казахстан улс руу тээвэрлэсэн.
- [2005-2007 он](#): Оюутолгой төслийн ачааг Хятадын Ганц мод боомтоор дамжуулан Гашуун Сухайтын боомтоор авто тээврээр тээвэрлэсэн.
- [2006 он](#): Чойрын замыг тавьсан замын тоног төхөөрөмжүүдийн тээвэрлэлтийг хийж гүйцэтгэсэн.
- [2008 он](#): Үндэсний хүнс, барилгын салбарын томоохон импортлогч болон үйлдвэрлэгч компани, аж ахуйн нэгжүүдийн тээвэрлэлтийг тогтмол тээвэрлэсэн.
- [2008-2010 он](#): Монгол улсын төмөр замаар хамгийн их ачаа тээвэрлэсэн тээвэр зуучийн компаниар шалгарч байсан.
- [2013 он](#): НВЦ компанийн Баянчандмань дахь тахианы байр, тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийг хийж гүйцэтгэсэн.
- [2014 он](#): Багахангайн цементийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, Чойр, Сайншандын салхин сэнсний тээвэрлэлтийг гүйцэтгэж байна.
- [2015 он](#): "Хөшигтийн хөндийн" дулааны цахилгаан станцын тоног төхөөрөмжийн тээврийг хийж гүйцэтгэж байна.

